

ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын тухай
хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан. Уг тогтоолын хавсралтад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай уялдуулан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар заасан. Монгол Улсын Засгийн газар Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаатай уялдуулан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай байна.

Өнөөгийн мөрдөгдөж байгаа Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдсөн. Эдийн засаг, бизнесийн харилцаа гүнзгийрч, техник, технологи хурдацтай хөгжиж, худалдаа үйлчилгээг хэрэглэгчдэд түгээх шинэлэг арга хэлбэрүүд бий болж байна. Улмаар зарим төрлийн ажил гүйлгээ, татварын харилцаанаас гадуур, зохицуулалтгүй үлдэх нөхцөл байдал бий болж байгаа бөгөөд татварын алба, татвар төлөгчийн хооронд маргаан үүсгэдэг. Нөгөө талаас, татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ойлгомжгүй заалтуудыг цэгцлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй байна.

Иймд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд дараах зохицуулалтыг шинээр тусгалаа:

1. Татварын хялбаршуулсан тогтолцоог нэвтрүүлэв. Одоогийн хуулиар аж ахуйн бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн албан татвараа нэг тайлангийн маягтаар, ижил хугацаанд тайлагнаж, төлдөг. Иймд хувиараа бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагнах ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагнал, төлөлтийн заалтуудыг хуулийн төсөлд тусгалаа. Үүний дагуу 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой хувь хүн өөрөө хүсвэл нийт татвар ногдох орлогын 1 хувьтай тэнцэх татварыг төлж, жилд 1 удаа тайлагнана.

2. Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого олж байгаа хувь хүний татварын харилцааг энгийн ойлгомжтой болгов. Бичил худалдаа, ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчид татварын тайлан гаргах, орлого, хасагдах зардлаа тооцох, татвар ногдуулах орлогоо тодорхойлоход хүндрэлтэй байдаг тул тэдгээрийн татварын харилцааг энгийн ойлгомжтой болгож, тогтмол дүнгээр татвар ногдуулахаар хуулийн төсөлд тусгаад байна.

3. Гадаад улсад төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох зарчмыг тусгав. Албан татвар төлөгчийн гадаад улсад төлсөн татварт хөнгөлөлт үзүүлэх туршлага олон улсад түгээмэл байдаг. Гэтэл өнөөгийн мөрдөгдөж байгаа Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу албан татвар төлөгч хувь хүний гадаад улсад төлсөн татварт хөнгөлөлт үзүүлэхдээ орлого ба хөрөнгийн

татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн хүрээнд хөнгөлөлт үзүүлдэг. Иймээс давхар татварыг бууруулах, албан татвар төлөгчийн татварын ачааллыг багасгах үүднээс түүний гадаад улсад төлсөн татварыг хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Түүнчлэн, одоо үйлчилж байгаа боловч зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай дараах зохицуулалт байна:

4. Байнга оршин суугч албан татвар төлөгчийн тодорхойлолтыг боловсронгуй болгов. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд Монгол Улсад байнга оршин суугч татвар төлөгчийг тодорхойлох, түүнд ногдуулах албан татварыг төлөх, тайлагнах зохицуулалт иж бүрэн тусгагдаагүй. Үүнээс үүдэн албан татвар төлөгч хувь хүнийг тодорхойлох үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нэмэгдэж, хууль хэрэгжүүлэх, түүнийг дагаж мөрдүүлэх зардал нэмэгддэг. Хуульд зарим төрлийн нэр томьёо, орлогын нэр төрлийг тодорхой зааж өгөөгүй байдаг тул хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал мөн адил бий болдог.

5. Татварын хувь хэмжээ хоорондоо уялдаагүй байсныг уялдуулж, хуулийн хэрэгжилтийг үр ашигтай болгоно. Монгол Улсад оршин суугч албан татвар төлөгч, Монгол Улсад оршин суугч бус татвар төлөгчийн олсон орлогод ногдуулах татварын хувь ялгаатай байдаг тул татварын ачаалал татвар төлөгчдөд жигд бус хуваарилагдах нөхцөл байдал үүсч байна. Хувь хэмжээ, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох зохицуулалтын ялгаатай байдлаас үүдэн суутгагчийн үүрэг хүлээж байгаа этгээд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар суутгахад зарцуулах цаг, зардал их байна.

6. Татвар ногдох орлогын ангилал, тодорхойлолтуудыг боловсронгуй болгов. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогын нэр төрөл, ангилал тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгосноор хуулийн хэрэгжилтийг нэг мөр, аливаа хийдэлгүй хангах боломж бүрдэнэ.


7. Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэйгээр олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох асуудлыг тодорхой болгов. Оршин суугч бус албан татвар төлөгчийн орлогод албан татвар ногдуулах харилцааг нарийвчлан зохицуулаагүй байдгаас хуулийг хэрэгжүүлэх явцад ойлгомжгүй, хүндрэлтэй байдал үүсч ирсэн тул тусгайлан зохицуулж, энгийн ойлгомжтой болголоо.

8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх харилцааг боловсронгуй болгов. Одоогийн хуулийн дагуу үзүүлдэг хөнгөлөлт, чөлөөлөлт нь зарим тохиолдолд үр ашиггүй, зорилтот бүлэгтээ хүрэхгүй байх эрсдэлтэй байдаг тул өмнө үзүүлж байсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татвар төлөгч татварын тайлангаа гаргаж, төлсний дараа буцаан олгодог байх харилцааг нэвтрүүлж байна. Ингэснээр татвар төлөгч илүү хариуцлагатай болох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой юм.

Хууль батлагдан гарснаар Хувь хүний орлогын албан татварын тухай хууль нь Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай

хуулийн шинэчлэлтэй нягт уялдах бөгөөд эдгээр хуулийг цогц байдлаар хэрэгжүүлэх боломжтой болно. Түүнчлэн, татвар төлөгч хувь хүний татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардал буурч, бизнесийг дэмжих, хөрөнгө оруулалтыг татах, ажлын байр шинээр бий болгоход тодорхой түлхэц болж өгнө.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан. Уг тогтоолын хавсралтад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай уялдуулан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах тухай заасан. Монгол Улсын Засгийн газар Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаатай уялдуулан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай байна.

Өнөөгийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдсөн. Эдийн засаг, бизнесийн харилцаа гүнзгийрч, техник, технологи хурдацтай хөгжиж, худалдаа үйлчилгээг хэрэглэгчдэд түгээх шинэлэг арга хэлбэрүүд бий болж байна. Улмаар зарим төрлийн ажил гүйлгээ, татварын харилцаанаас гадуур, зохицуулалтгүй үлдэх нөхцөл байдал бий болж байгаа бөгөөд татварын алба, татвар төлөгчийн хооронд маргаан үүсгэдэг. Нөгөө талаас, татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ойлгомжгүй заалтуудыг цэгцлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй байна.

Иймд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд дараах зохицуулалтыг шинээр тусгалаа:

1.Татварын хялбаршуулсан тогтолцоог нэвтрүүлнэ. Одоогийн хуулиар аж ахуйн бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн албан татвараа нэг тайлангийн маягтаар, ижил хугацаанд тайлагнаж, төлдөг. Иймд хувиараа бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагнах ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагнал, төлөлтийн заалтуудыг хуулийн төсөлд тусгалаа. Үүний дагуу 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой хувь хүн өөрөө хүсвэл нийт татвар ногдох орлогын 1 хувьтай тэнцэх татварыг төлж, жилд 1 удаа тайлагнана.

2.Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого олж буй хувь хүний татварын харилцааг энгийн ойлгомжтой болгоно. Бичил худалдаа, ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчид татварын тайлан гаргах, орлого, хасагдах зардлаа тооцох, татвар ногдуулах орлогоо тодорхойлоход хүндрэлтэй байдаг тул тэдгээрийн татварын

харилцааг энгийн ойлгомжтой болгож, тогтмол дүнгээр татвар ногдуулахаар хуулийн төсөлд тусгаад байна.

3. Гадаад улсад төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох зарчмыг тусгана. Албан татвар төлөгчийн гадаад улсад төлсөн татварт хөнгөлөлт үзүүлэх туршлага олон улсад түгээмэл байдаг. Гэтэл өнөөгийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу албан татвар төлөгч хувь хүний гадаад улсад төлсөн татварт хөнгөлөлт үзүүлэхдээ орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн хүрээнд хөнгөлөлт үзүүлдэг. Иймээс давхар татварыг бууруулах, албан татвар төлөгчийн татварын ачааллыг багасгах үүднээс түүний гадаад улсад төлсөн татварыг хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Түүнчлэн, одоо үйлчилж байгаа боловч зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай дараах зохицуулалт байна:

4. Байнга оршин суугч албан татвар төлөгчийн тодорхойлолтыг боловсронгуй болгоно. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд Монгол Улсад байнга оршин суугч татвар төлөгчийг тодорхойлох, түүнд ногдуулах албан татварыг төлөх, тайлагнах зохицуулалт иж бүрэн тусгагдаагүй. Үүнээс үүдэн албан татвар төлөгч хувь хүнийг тодорхойлох үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нэмэгдэж, хууль хэрэгжүүлэх, түүнийг дагаж мөрдүүлэх зардал нэмэгддэг. Хуульд зарим төрлийн нэр томьёо, орлогын нэр төрлийг тодорхой зааж өгөөгүй байдгаас хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл бий болдог.

5. Татварын хувь хэмжээ хоорондоо үялдаагүй байсныг үялдуулж, хуулийн хэрэгжилтийг үр ашигтай болгоно. Монгол Улсад оршин суугч албан татвар төлөгч, Монгол Улсад оршин суугч бус татвар төлөгчийн олсон орлогод ногдуулах татварын хувь ялгаатай байдаг тул татварын ачаалал татвар төлөгчдөд жигд бус хуваарилагдах нөхцөл байдал үүсэж байна. Хувь хэмжээ, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох зохицуулалтын ялгаатай байдлаас үүдэн суутгагчийн үүрэг хүлээж буй этгээд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар суутгахад зарцуулах цаг, зардал их байна.

6. Татвар ногдох орлогын ангилал, тодорхойлолтуудыг боловсронгуй болгоно. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогын нэр төрөл, ангилал тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгосноор хуулийн хэрэгжилтийг нэг мөр, аливаа хийдэлгүй хангах боломж бүрдэнэ.

7. Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэйгээр олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох асуудлыг тодорхой болгоно. Оршин суугч бус албан татвар төлөгчийн орлогод албан татвар ногдуулах харилцааг нарийвчлан зохицуулаагүй байдгаас хуулийг хэрэгжүүлэх явцад ойлгомжгүй, хүндрэлтэй байдал үүсч ирсэн тул тусгайлан зохицуулж, энгийн ойлгомжтой болголоо.

8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх харилцааг боловсронгуй болгоно. Одоогийн хуулийн дагуу үзүүлдэг хөнгөлөлт, чөлөөлөлт нь зарим тохиолдолд үр ашиггүй, зорилтод бүлэгтээ хүрэхгүй байх эрсдэлтэй байдаг тул өмнө үзүүлж байсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татвар төлөгч татварын тайлангаа гаргаж, төлсний

дараа буцаан олгодог байх харилцааг нэвтрүүлж байна. Ингэснээр татвар төлөгч илүү хариуцлагатай болох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой юм.

Хоёр.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын зорилго нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, тус албан татварыг төсөвт төвлөрүүлэх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулах болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 7 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- Хуулийн төслийн нэгдүгээр бүлгээр хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томъёо, татвар төлөгчийн тодорхойлолт;
- Хуулийн төслийн хоёрдугаар бүлгээр албан татвар ногдох орлого, орлогын ангилал, орлого хүлээн зөвшөөрөх, тодорхойлох зарчим;
- Хуулийн төслийн гуравдугаар бүлгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох;
- Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлгээр албан татварын хувь, хэмжээ;
- Хуулийн төслийн тавдугаар бүлгээр албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, гадаад улсад төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох;
- Хуулийн төслийн зургадугаар бүлгээр албан татвар суутгах, төсөвт төлөх, тайлагнах;
- Хуулийн төслийн долдугаар бүлгээр хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тус тус тусгасан болно.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хууль батлагдан гарснаар Хувь хүний орлогын албан татварын тухай хууль нь Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчлэлтэй нягт уялдах бөгөөд эдгээр хуулийг цогц байдлаар хэрэгжүүлэх боломжтой болно. Түүнчлэн, татвар төлөгч хувь хүний татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардал буурч, бизнесийг дэмжих, хөрөнгө оруулалтыг татах, ажлын байр шинээр бий болгоход тодорхой түлхэц болж өгнө.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиуд болон Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэн боловсруулах бөгөөд тэдгээртэй зөрчилдөхгүй. Хуулийн төсөлтэй хамт өнөөгийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ (шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1.Хувь хүний орлогын албан татвар /цаашид "албан татвар" гэх/-ын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хувь хүний орлогод албан татвар ногдуулах харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аж ахуйн нэгж” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.2.“биет бус хөрөнгө” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.3.“бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч” гэж ажлын байр,лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй худалдаа, үйлчилгээ, зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь хүнийг;

4.1.4.“гадаад улсад олсон орлого” гэж энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д зааснаас бусад орлого;

4.1.5.“малчин өрх” гэж малыг байнга маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог гэр бүлийг;

4.1.6.“мал бүхий этгээд” гэж энэ хуулийн 4.1.5-д зааснаас бусад мал өмчилж байгаа хувь хүнийг;

4.1.7.“Монгол Улсад олсон орлого” гэж албан татвар төлөгчийн Монгол Улсад олсон энэ хуулийн 6.3-д заасан орлогыг;

4.1.8.“Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.7-д заасантай адилтгах, хувь хүнд хамаарах орлогыг;

4.1.9.“үл хөдлөх эд хөрөнгө” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.9-д заасныг;

4.1.10.“тогтмол бус үйл ажиллагаа” гэдэгт тухайн хувь хүний хууль буюу гэрээгээр байнга эрхлэх ажил үүрэгтэй нь холбоогүй, орлогын тогтмол эх үүсвэр болдоггүй ажил, үйлчилгээг хамааруулна;

4.1.11.“суутган төлөгч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.19-д заасныг.

5 дугаар зүйл. Албан татвар төлөгч

5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.

5.2.Албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна.

5.3.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж доор дурдсан нөхцөлийн аль нэгийг хангасан хувь хүнийг хэлнэ:

5.3.1.үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суусан;

5.3.2.албан татвар ногдох орлогын 50 болон түүнээс дээш хувийг Монгол Улсад олсон орлого болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого эзэлж байвал.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийг тодорхойлоход энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан дарааллыг баримтална.

5.5.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчид Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон, энэ хуулийн 5.3, 5.6-д зааснаас бусад хувь хүнийг хамруулна.

5.6.Гадаад улсад томилогдон ажиллаж байгаа Монгол Улсын төрийн албан хаагч Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч байна.

5.7.Энэ хуулийн 5.3.1-д заасан хугацааг Монгол Улсын хилээр орсон өдрөөс хуанлийн хоногоор тоолох бөгөөд олон удаа орж гарсан тохиолдолд албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хоногийн нийлбэрээр тодорхойлно.

5.8.Энэ хуулийн 5.7-д заасан нийлбэрийг тодорхойлоход тухайн татварын жил болон түүний өмнөх татварын жилийг хамруулан тооцно.

5.9.Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүд нь Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчид хамаарахгүй.

5.10.Албан татвар төлөгч үргэлжилсэн 12 сарын хугацаанд Монгол Улсад 183 хоног ба түүнээс дээш хоног ажиллах нь хөдөлмөрийн гэрээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлөөр нотлогдож байвал уг албан татвар төлөгч Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчөөр бүртгүүлж болно.

5.11.Энэ зүйлд заасан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, албан татварын тооцоо хийхтэй холбогдсон журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АЛБАН ТАТВАР НОГДОХ ОРЛОГО

6 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого

6.1.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй, түүнчлэн гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

6.2.Энэ хуулийн 5.5-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно.

6.3.Албан татвар төлөгчийн дараахь орлогод албан татвар ногдоно:

6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

6.3.2.үйл ажиллагааны орлого;

6.3.3.хөрөнгийн орлого;

6.3.4.хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

6.3.5.шууд бус орлого;

6.3.6.бусад орлого.

7 дугаар зүйл. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого

7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараахь орлого хамаарна:

7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

7.1.2.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;

7.1.3.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;

7.1.4.төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

7.1.5.гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

7.1.6.үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

7.1.7.бэлнээр олгосон хоол, унааны мөнгө.

8 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлого

8.1.Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж олсон дараахь орлогыг хамруулна:

8.1.1.бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;

8.1.2.хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зэргээр олсон орлого;

8.1.3.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

8.1.4.эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээ.

8.2.Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

8.3.Малчин өрх, мал бүхий этгээдийн малын ашиг шимээс олдог орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

9 дүгээр зүйл. Хөрөнгийн орлого

9.1.Хөрөнгийн орлогод дараахь орлого хамаарна:

- 9.1.1.хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;
- 9.1.2.эрхийн шимтгэлийн орлого;
- 9.1.3.ногдол ашгийн орлого;
- 9.1.4.хүүгийн орлого.

9.2.Эрхийн шимтгэлийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.2-т заасныг хамааруулна.

9.3.Ногдол ашгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.3-т заасныг хамааруулна.

9.4.Хүүгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.4-т заасныг хамааруулна.

10 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого

10.1.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод дараахь орлого хамаарна:

- 10.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;
- 10.1.2.газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;
- 10.1.3.хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;
- 10.1.4.хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого.

10.2.Биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар төлөгч өөрийн эдийн бус хөрөнгө өмчлөх эрхийг хуульд заасны дагуу бусдад шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

11 дүгээр зүйл. Шууд бус орлого

11.1.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараахь бараа, ажил, үйлчилгээний орлогыг шууд бус орлогод хамруулна:

- 11.1.1.үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн;
- 11.1.2.орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрны хөлс, түлшний зардлын төлбөр;
- 11.1.3.үзвэр үйлчилгээний олговор;
- 11.1.4.ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгчийн болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр;

11.1.5.ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;
11.1.6.арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;

11.1.7.ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж;

11.1.8.гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр;

11.1.9.Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбоотой гарах зардлын төлбөр;

11.1.10.эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл;

11.1.11.энэ хуулийн 11.1.1-11.1.10-т заасантай адилтгах бусад орлого.

11.2.Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараахь шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамааруулахгүй:

11.2.1.цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан;

11.2.2.амрах байр, бусад үйлчилгээгээр хангах, тухайн ажлын байранд ирэх, буцахад нэгдсэн журмаар унаагаар үйлчилсэн;

11.2.3.орон сууц худалдан авах, барихад зориулж ажилтанд арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;

11.2.4.эрүүл мэндийн байгууллагад төлсөн эмчилгээний зардалд зориулж олгосон тусламж, дэмжлэг;

11.2.5.ажил олгогчоос олгож байгаа албан томилолтын зардал;

11.2.6.хууль тогтоомжийн дагуу ажил олгогчоос олгож байгаа хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцас, хор саармагжуулах ундааны үнэ, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн зардал;

11.2.7.хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор ажил олгогчийн төлсөн сайн дурын амь нас, эрүүл мэнд, гэнэтийн осол болон мэргэжлийн хариуцлагын даатгалын хураамж.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан шууд бус орлогыг ажил олгогчоос уг орлогыг олгохтой холбогдон гарсан зардлын дүнгээр тодорхойлно.

12 дугаар зүйл. Бусад орлого

12.1.Энэ хуулийн 6.3.6-д заасан орлогод дараахь орлогыг хамруулна:

12.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;

12.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого;

12.1.3.бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого.

13 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогыг тодорхойлох

13.1.Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдсөн орлогыг хасаж тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ

14 дүгээр зүйл. Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

14.1.Энэ хуулийн 7.1-д заасан цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна.

15 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

15.1.Үйл ажиллагааны орлогод албан татварын ногдуулах орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1-д заасан шаардлагыг хангасан зардлыг хасаж, 13.2-т заасан зарчмыг баримталж, 14-17 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан хасагдах зардлыг албан татвар төлөгч хувийн хэрэглээндээ зарцуулсан бол албан татвар ногдох орлогоос хасахгүй.

15.3.Албан татвар төлөгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал түүнд ногдох үйл ажиллагааны зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохгүй.

15.4.Албан татвар төлөгч нь үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж байгаа машин, механизм, тоног төхөөрөмж, барилгыг гэр бүлийнхээ хэрэгцээнд нэгэн зэрэг ашиглаж байгаа бол ашиглалтын зардлыг хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тусгана.

15.5.Албан татвар төлөгчийн гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно.

15.6.Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөг хүртэлх хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяалах

татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

15.7.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхтэй албан татвар төлөгч энэ хуулийн 15.6-д заасан хүсэлт гаргахгүй.

15.8.Энэ хуулийн 15.6-д заасан хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасах журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

16 дугаар зүйл. Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

16.1.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

16.1.1.хөрөнгө ашиглуулсны эсхүл түрээслүүлсний нийт орлогоос тухайн хөрөнгийг ашиглуулах эсхүл түрээслүүлэхтэй холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр нь;

16.1.2.эрхийн шимтгэлийн орлогыг нийт дүнгээр;

16.1.3.ногдол ашгийн орлогыг нийт дүнгээр;

16.1.4.хүүгийн орлогыг нийт дүнгээр.

16.2.Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол албан татвар ногдуулах орлогыг албан татвар төлөгчийн эзэмшилд байгаа хувьцаа болон хувь нийлүүлсэн хөрөнгөнд хувь тэнцүүлэн хуваарилсан орлогын дүнгээс уг хувьцаа болон хөрөнгийг анх худалдан авсан үнэ, хувь нийлүүлэхдээ гаргасан зардлыг хасаж тодорхойлно.

17 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

17.1.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

17.1.1.энэ хуулийн 10.1.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгө борлуулж олсон орлогыг нийт дүнгээр нь;

17.1.2.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогоос доор дурдсан баримтаар нотлогдох зардлуудыг хассан дүнгээр нь:

17.1.2.а.эрх авахтай холбогдуулан төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох төлбөр;

17.1.2.б.хөрөнгийг худалдаж, шилжүүлж авах болон эдгээртэй холбогдуулан төлсөн баримтаар нотлогдох зардал;

17.1.3.энэ хуулийн 10.1.4-т заасан хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлогоос уг хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээр;

17.1.4.хамтран эзэмшиж байсан хувьцаа, үнэт цаас борлуулсан бол энэ хуулийн 17.1.3-т заасны дагуу хассан дүнг тодорхойлсны дараа тухайн албан татвар төлөгчид ногдох хэсгийн үнийн дүнгээр тодорхойлно.

17.2.Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ тооцох, албан татварын ногдуулах орлогыг тодорхойлоход Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6-д заасан аргачлалыг баримтална.

18 дугаар зүйл. Шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

18.1.Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно.

19 дүгээр зүйл. Бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

19.1.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

19.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

19.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр.

19.2.Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч албан татвар төлөгч нь тайлант жилд олсон орлогоо өөрийн хүсэлтээр энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан орлогод хамааруулан, албан татвар ногдуулан төлж, тайлагнаж болно.

20 дугаар зүйл. Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

20.1.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

20.2.Монгол Улсад оршин суугч этгээд болон Монгол Улсад оршин суугч бус этгээд хороонд байгуулсан аж ахуйн үйл ажиллагааны гэрээний дагуу тухайн оршин суугч бус этгээдийг төлөөлж Монгол Улсад хүрэлцэн ирж ажилласан хувь хүнд

Монгол Улсад оршин суугч этгээдээс олгосон орлогыг тодорхойлоход талууд гэрээнд Монгол Улсад хүрэлцэн ирж ажилласан хувь хүний орлогыг ангилж тусгасан байна.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан нөхцөл нь гэрээнд тодорхой тусгагдаагүй тохиолдолд гэрээний үнийн тооцоололд багтсан тухайн хувь хүний Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллахтай холбогдон гарсан зардлын дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ

21 дүгээр зүйл. Албан татварын хувь, хэмжээ

21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.

21.2.Энэ хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна:

21.2.1.энэ хуулийн 17.1.1-д заасан орлогын дүнд 2 хувиар;

21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар;

21.2.3.энэ хуулийн 19.1.2-т заасан орлогын дүнд 40 хувиар;

21.2.4.энэ хуулийн 16 дугаар зүйл, 15.1, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар;

21.2.5.энэ хуулийн 20.1-д заасан орлогын дүнд 20 хувиар.

21.3.Энэ хуулийн 15.6-д заасан орлогод 1 хувиар албан татвар ногдуулна.

21.4.Энэ хуулийн 12.1.3-т заасан орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал доор дурдсан хязгаарт багтаан тогтооно:

21.4.1.ажлын байр, лангуу бүхий байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд албан татварын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувь, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээнд;

21.4.2.хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд албан татварын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувь, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээнд.

21.5.Энэ хуулийн 21.2.4, 21.2.5-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

22 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх орлого

22.1. Дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө:

22.1.1. хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;

22.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;

22.1.3. гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд үзүүлж байгаа тусламж;

22.1.4. малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлого;

22.1.5. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын болон Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;

22.1.6. Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээдүүд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого;

22.1.7. нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллаас орсон орлого;

22.1.8. энэ хуулийн 5.9-д заасан хувь хүний цалин, нэмэгдэл;

22.1.9. энэ хуулийн 22.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн гадаад улсад олсон орлого.

22.2. Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан хувиар албан татвар төлж байгаа хувь хүн энэ зүйлд заасан чөлөөлөлт үзүүлэхгүй.

23 дугаар зүйл. Албан татварын хөнгөлөлт

23.1. Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/
0-6 000 000 хүртэл	240 000
6 000 000-12 000 000 хүртэл	216 000
12 000 000-18 000 000 хүртэл	192 000
18 000 000-24 000 000 хүртэл	168 000
24 000 000-30 000 000 хүртэл	144 000

30 000 000-36 000 000 хүртэл	120 000
36 000 000 ба түүнээс дээш	-

23.2. Доор дурдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн болон тариалсан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө:

- 23.2.1. үр тариа;
- 23.2.2. төмс, хүнсний ногоо, түүний үр;
- 23.2.3. жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац;
- 23.2.4. тэжээлийн ургамал;
- 23.2.5. модны суулгац.

23.3. Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар ипотекийн зээлийн хөрөнгөөр хувьдаа, анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Монгол Улсын Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.

23.4. Монгол Улсын иргэн өөрийн албан татвар ногдсон орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар зөвхөн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол ийнхүү орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авахад зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг уг албан татвар төлөгчид эдлүүлэх бөгөөд энэ хөнгөлөлтийн хэмжээ 6 сая төгрөг хүртэл байна.

23.5. Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж байгаа тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож байгаа сургалтын төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.

23.6. Монгол Улсын иргэн суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд болон мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, коллежид анхлан суралцагчийг энэ хуулийн 23.5-д заасан хөнгөлөлтөд хамруулна.

23.7. Албан татвар төлөгч өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан бол ийнхүү худалдан авсан баримтаар нотлогдож байгаа төлбөртэй тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.

23.8.Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчид эдлүүлнэ.

23.9.Албан татвар төлөгчийн дараахь орлогод ногдох албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:

23.9.1.донорын олговор;

23.9.2.даатгалын нөхөн төлбөр;

23.9.3.Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал.

23.10.Энэ хуулийн 23.7-д заасан тоног төхөөрөмж, бараа материалын жагсаалтыг Засгийн газар батална.

23.11.Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан хувиар албан татвар төлж байгаа хувь хүн энэ зүйлд заасан хөнгөлөлт эдлэхгүй.

23.12.Албан татвар төлөгч энэ хуулийн 23.3, 23.4-т заасан хөнгөлөлтийн аль нэгийг сонгон эдэлнэ.

23.13.Тайлант жилд албан татварын хөнгөлөлтийг тухайн орлогод ногдуулан төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй.

23.14.Энэ хуулийн 22.1-д заасан чөлөөлөлт болон энэ зүйлд заасан хөнгөлөлт эдлүүлэх журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

24 дүгээр зүйл. Гадаад улсад ногдуулсан албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох

24.1.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн гадаад улсад төлсөн албан татварыг тус албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээ нь албан татвар төлөгчийн тухай татварын жилд Монгол Улсад төлбөл зохих татварын дүнгээс хэтрэхгүй байна.

24.3.Энэ хуулийн 24.1-д заасны дагуу гадаад улсад ногдуулсан албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийг баримтална.

24.4.Гадаад улсад ногдуулан төлсөн татварыг баталгаажуулах, төлбөл зохих татвараас хасаж тооцох журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ, ТӨСӨВТ ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ,
ХАСАЛТ ХИЙХ, БУЦААН ОЛГОХ

25 дугаар зүйл. Албан татвар суутган тооцох, төсөвт төлөх

25.1.Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална:

25.1.1.энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.2.энэ хуулийн 16.1.2-16.1.4-т заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.3.энэ хуулийн 17.1.1-д заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.4.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.2-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.5.энэ хуулийн 19.1.2-т заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.3-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.6.энэ хуулийн 20.1-д заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.5-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.7.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогын дүнд 21.5-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх.

25.2.Албан татвар төлөгчийн харилцах данс, хадгаламжид хүү бодох бүрдээ банк, санхүүгийн байгууллага нь суутган төлөгчийн үүрэг хүлээж албан татвар ногдуулан суутгаж, төсөвт шилжүүлнэ.

25.3.Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно.

25.4.Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэнэ.

25.5.Суутган төлөгч энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийн хэмжээг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ.

25.6.Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор төсөвт шилжүүлнэ.

26 дугаар зүйл. Албан татварыг өөрөө тодорхойлж, төсөвт төлөх

26.1.Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, дор дурдсан хугацаанд албан татварыг төсөвт төлнө:

26.1.1.энэ хуулийн 15.1, 16.1.1, 17.1.2, 17.1.3-т тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар тооцон тухай бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор;

26.1.2.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 16.1.2-16.1.4-т заасан орлогод энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

26.1.3.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 17.1.1-д тодорхойлсон орлогод 21.2.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

26.1.4.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогод 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

26.1.5.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 19.1.1-д заасан орлогод 21.2.2-т заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

26.1.6.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 19.1.2-т заасан орлогод 21.2.3-т заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

26.1.7.энэ хуулийн 15.6-д тодорхойлсон орлогод 21.3-т заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

26.2.Энэ хуулийн 21.4-т заасан татварыг бичил, худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь уг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ олгохдоо хураан авч, тухай бүр төсөвт төвлөрүүлнэ.

26.3.Энэ хуулийн 4.1.3-т заасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч нь албан татвар төлснийг нотлох зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг биедээ авч явна, эсхүл тээврийн хэрэгсэлдээ ил байрлуулна.

26.4.Энэ хуулийн 26.2-т заасан зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг авсан албан татвар төлөгчийн албан татвар төлснийг нотлох баримтын загварыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

26.5.Энэ хуульд заасны дагуу албан татварын тайлан гаргах үүрэг хүлээгээгүй албан татвар төлөгч өөрийн хүсэлтээр тухайн жилийн татварын тайлан гаргаж, дараа жилийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор татварын албанд хүргүүлэн, жилийн эцсийн тооцоо хийж болно.

27 дугаар зүйл. Албан татвар тайлан хүргүүлэх хугацаа

27.1.Суутган төлөгч нь энэ хуулийн 14, 16.1.2-16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

27.2.Албан татвар төлөгч энэ хуулийн 15.1, 15.6, 16.1.1, 17.1.2, 17.1.3-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

27.3.Бичил, худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь энэ хуулийн 26.2-т заасны дагуу хураан авсан албан татварын тайланг харьяа татварын албанд дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

27.4.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн гадаад улсад олсон энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2-т заасан орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

27.5.Энэ хуулийн 22.1.2, 22.1.4, 22.1.7, 23.1-д зааснаас бусад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах албан татвар төлөгч албан татварын тайлан тушаах үүрэгтэй бөгөөд уг тайлан нь түүнийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.

27.6.Албан татвар төлөгч татварын жил дуусахаас өмнө тухайн татварын жилд хамаарах албан татварын тайлан гаргаж, холбогдох тооцоог урьдчилан хийж болно.

28 дугаар зүйл. Албан татварын буцаан олголт

28.1.Албан татвар төлөгч, суутган төлөгчийн энэ хуулийн 27.1, 27.2, 27.4, 27.5, 27.6-д заасны дагуу хүргүүлсэн тайлангаар албан татварын илүү, дутуу төлөлтийн тооцооллыг харьяалах татварын алба дараахь журмаар нягталж, эцсийн тооцоо хийнэ:

28.1.1.татварын жилд албан татвар төлөгчид буцаан олгох татварын хэмжээ нь энэ хуулийн 23.13-т зааснаар хязгаарлагдана;

28.1.2.албан татвар төлөгч энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эхэлж эдэлнэ;

28.1.3.энэ хуулийн 23.1-д зааснаас бусад хөнгөлөлтийг албан татвар төлөгч мөн хуулийн 28.1.1-д заасан хязгаарт багтаан өөрөө сонгон эдэлнэ;

28.1.4.албан татвар төлөгч энэ хуульд заасан хөнгөлөлтийг хэсэгчлэн эдлэхгүй;

28.1.5.энэ хуулийн 23.4-т зааснаас бусад хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн эдлүүлэхгүй.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар нь төлбөл зохих албан татварын хэмжээнээс бага тохиолдолд харьяалах татварын алба албан татвар төлөгчид мэдэгдэж, эцсийн тооцоог хийж, зөрүүг төлүүлнэ.

28.3.Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар, төлбөл зохих албан татварын хэмжээнээс давсан тохиолдолд илүү гарсан дүнг Татварын ерөнхий хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

28.4.Энэ хуулийн 28.3-т заасан албан татвар төлөгчийн буцаан авах, илүү төлсөн татварыг дараахь журмаар буцаан олгоно:

28.4.1.буцаан олголтыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан албан татвар төлөгчид буцаан олгоно;

28.4.2.харьяа татварын алба энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан тайлан хүргүүлэх хугацаанаас хойш ажлын 20 өдөрт багтаан буцаан олгох татварын хэмжээг хянан тодорхойлж, харьяалах төрийн сангийн нэгжид хүргүүлнэ;

28.4.3.энэ хуулийн 28.4.1-д заасан буцаан олголтыг дараа жилийн 2 дугаар улиралд багтаан олгоно.

28.5.Энэ хуулийн 28.4-т заасан албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Албан татвар төлөгч хувь хүний 2018 оны татварын жилд олсон орлогод ногдуулан төлөх албан татварын хэмжээг 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу тодорхойлон тайлагнаж, эцсийн тооцоог хийнэ.

2 дугаар зүйл. Суутган төлөгч нь албан татвар төлөгчид 2018 оны татварын жилд олгосон орлогод 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, төсөвт төвлөрүүлж, тайлагнана.

3 дугаар зүйл. Албан татвар төлөгч хувь хүний 2018 оны татварын жилд олсон орлогод эдлүүлэх, энэ хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу тодорхойлж, 2019 оны татварын жилд эдлүүлнэ.

4 дүгээр зүйл. Албан татвар төлөгч хувь хүний 2018 оны татварын жилд олсон орлогод эдлүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтөд энэ хуулийн 3 дугаар зүйл хамаарахгүй.

5 дугаар зүйл. 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.12, 24.6-д заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг албан татвар төлөгч 2018 оны татварын жилд бүрэн эдэлж дусаагүй тохиолдолд үлдэх хэсгийг 2019 оны татварын жилээс эхлэн үргэлжлүүлэн эдлүүлнэ.

6 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.3.1-д заасан хугацааг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тоолно.

7 дугаар зүйл. Хувь хүний 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө худалдан авсан, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан зарчмыг баримтална.

8 дугаар зүйл. Энэ хуулийг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 23.6.6, 23.8.1 дэх заалтын “8.1.1” гэснийг “7.1” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 23.8.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан. Уг тогтоолын хавсралтад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай уялдуулан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах тухай заасан.

Монгол Улсын Засгийн газар хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, татварын хууль тогтоомжийг энгийн, ойлгомжтой болгож, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг татварын хууль тогтоомжид тусгах зорилгоор Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаатай уялдуулан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлага бий болоод байна.

Өнөөгийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдсөн. Эдийн засаг, бизнесийн харилцаа гүнзгийрч, техник, технологи хурдацтай хөгжиж, худалдаа үйлчилгээг хэрэглэгчдэд түгээх шинэлэг арга хэлбэрүүд бий болж байна. Улмаар зарим төрлийн ажил гүйлгээ, албан татварын харилцаанаас гадуур, зохицуулалтгүй үлдэх нөхцөл байдал бий болж байгаа бөгөөд татварын алба, татвар төлөгчийн хооронд маргаан үүсгэдэг. Нөгөө талаас, татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ойлгомжгүй, хийдэлтэй заалтуудыг цэгцлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй байна.

Эдийн засгийн өсөлт нэмэгдэж, төсвийн орлогын гүйцэтгэл сайжирч буй энэ үед татварын шинэчлэлийг хийж, иргэдийн татвар төлөх идэвхийг нэмэгдүүлэх, олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх, татварын суурийг өргөтгөх, бүртгэлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж үзэж байгаа болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹ /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Өнөөгийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэ хуулиар хувь хүний орлогод албан татвар ногдуулах, тус албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Эдийн засгийн болон бизнесийн харилцаа гүнзгийрч, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний шинэ хэлбэр, ажил гүйлгээ бий болж байгаатай уялдуулан одоогийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэх шаардлагатай байна. Нөгөө

¹Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

талаас, Засгийн газар Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа тул Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслийг эдгээр хуулийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу тухайн асуудалд дүн шинжилгээ хийхдээ зорилго, зорилтыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа зүйлийн мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг дэмжих, татварын хууль тогтоомжийг боловсронгуй, энгийн, ойлгомжтой болгох, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, татварын хууль тогтоомж дагаж мөрдөх зардлыг бууруулах, татварын албаны чадавхыг бэхжүүлэх зорилгоор татварын шинэчлэлийн ажлыг Засгийн газар эхлүүлээд байна. Энэ хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг боловсронгуй болгох, ойлгомжгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зарим зүйл, заалтыг цэгцлэх, татварын бусад хуультай уялдуулах шаардлагатай байна. Хуулиар хувь хүний орлогод албан татвар ногдуулах, тус албан татварыг төсөвт төлөх, тайлагнах, буцаан олгох асуудлыг авч үзнэ.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд дараах этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөнө:

1. Албан татвар ногдох орлого олсон Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч хувь хүн;
2. Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон Монгол Улсад байнга оршин суугч бус хувь хүн;
3. Хувь хүний орлогод албан татвар суутган төсөвт шилжүүлэх үүрэг бүхий хуулийн этгээд.

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Одоо мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэх дараах үндэслэл, шаардлага байна. Үүнд:

1. Өнгөрсөн 12 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийн бүтэц, бизнесийн орчин, олон улсын бизнесийн харилцаан дахь оролцоо эрс өөрчлөгдсөнийг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль бүрэн зохицуулах боломжгүй байна;
2. Хувь хүний орлогын албан татварын зарим зүйл заалт ойлгомжгүй, салаа утгатай байгаа тул хуулийг хэрэгжүүлэх зардал нэмэгдэж, татварын алба, татварын төлөгч хооронд үл ойлголцол бий болж байна;
3. Тодорхой төрлийн ажил гүйлгээнд хувь хүний орлогын албан татвар ногдуулах харилцаа орхигдсон байдаг. Тухайлбал, биет бус хөрөнгө борлуулах үйл ажиллагаанаас олсон орлогод ногдуулах албан татварын харилцаа орхигдсон;

4. Зарим төрлийн татварын хувь хэмжээг бууруулах замаар хөрөнгө оруулагч, татвар төлөгчийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих замаар хөрөнгө оруулалтыг татах, ажлын байр шинээр бий болгох;

5. Засгийн газрын авч хэрэгжүүлж буй бодлоготой уялдуулах. Ялангуяа, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр, арга хэмжээг дэмжих шаардлага үүссэн;

6. Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаатай уялдуулан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэх. Тухайлбал, хувь хүний үйл ажиллагааны орлогод ногдуулах албан татварыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан зарчмыг баримтлах шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд гарч буй техник, технологийн дэвшил нь татварын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх ойлголтыг эрс өөрчилж байна. Тухайлбал, 2016 оноос хэрэгжиж эхэлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн дагуу эдийн засагт эрчимтэй хэрэглэгдэж буй цахим төлбөрийн баримтын систем нь татварын албаны бүртгэл, мэдээллийн хүчин чадлыг эрс нэмэгдүүлж байна. Түүнчлэн, татварын цахим тайлагнал, төлөлт болон бусад үйлчилгээ тасралтгүй нэвтэрч, татвар төлөгчдийн татварын зардлыг бууруулж байгааг хууль тогтоомжид тусган цаашид улам бүр хөгжүүлэх нь зүйтэй байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хөрөнгө оруулалт, бизнесийг дэмжсэн, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ажлын байр шинээр бий болгох, тэгш шударга, үр ашигтай татварын тогтолцоог бий болгох, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуультай уялдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулахыг зорьж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАНУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу *“Хөрөнгө оруулалт, бизнесийг дэмжсэн, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ажлын байр шинээр бий болгох, тэгш шударга, үр ашигтай татварын тогтолцоог бий болгох, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуультай уялдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах”* зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1 Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа хүндрэл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ. Татварын суурь багасна.	Үр дүнд хүрэхгүй
2 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа	Өнөөгийн тулгамдаад байгаа хүндрэл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй.

	хийх			
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан зохицуулах замаар зорилгод хүрэх боломжгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул төрөөс санхүүгийн интервенц хийх замаар зорилгод хүрэх боломжгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул хуулиар эрх олгогдоогүй тохиолдолд захиргааны шийдвэр гаргах замаар зорилгод хүрэх боломжгүй.	Зардал гарахгүй. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул хуулийн төсөл боловсруулах замаар зорилгод хүрэх боломжтой.	Одоо үйл ажиллагаа явуулж буй татварын албаны нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх учир нэмэлт зардал гарахгүй. Татварын хялбаршуулсан горимыг нэвтрүүлж, татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгосноор иргэд, аж ахуйн нэгжийн татварын хууль тогтоомж дагах зардал буурч, татварын суурь өргөжиж, төсвийн орлого нэмэгдэнэ.	Үр дүнтэй

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад заасны дагуу албан татварын бодлогыг тодорхойлох нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал гэж, Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй хэмээн тус тус заасан байдаг. Иймд татварын харилцааг шинэчлэн сайжруулах асуудлыг хууль тогтоомжийн төсөл боловсруулахаас бусад дээр дурдсан хувилбараар шийдвэрлэх боломжгүй юм.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгон, татварын албаны нөөц бололцоонд тулгуурлан шаардлагатай бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх учир нэмэлт зардал гарахгүй. Харин татварын хялбаршуулсан горимыг нэвтрүүлсэн тохиолдолд иргэд, аж ахуйн нэгжүүдийн татвартай холбоотой гардаг зардал буурна. Түүнчлэн, хуулийн тогтоомжийн төсөлд бизнесийн орчин, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр зарим хэлбэрээр татварын ачааллыг бууруулах тул хувь хүний албан татварын дарамт буурна. Нөгөөтээгүүр, эдийн засгийн өсөлт, бизнесийн орчин тэлж, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр татварын суурь өргөжиж, төсвийн орлого нэмэгдэнэ.

Ийнхүү асуудлыг зохицуулах хувилбаруудыг харьцуулан дүгнэхэд *Хөрөнгө оруулалт, бизнесийг дэмжсэн, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ажлын байр шинээр бий болгох, тэгш шударга, үр ашигтай татварын тогтолцоог бий*

болгох, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуультай уялдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах зохицуулалтын хувилбарыг авч хэрэглэх шаардлагатай байгаа тул Аргачлалд заасны дагуу тандан судлах ажиллагааг үргэлжлүүлэн хийж байна.

Иймд тухайн хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг дараах байдлаар ерөнхийлөн томъёолж байна.

Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг Аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4, 5-аас үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хувилбар 6-гийн хүрээнд хувь хүний орлогын албан татварын харилцааг нарийвчлан зааж өгснөөр эрх зүйн харилцаа илүү боловсронгуй болж, татварын тэгш шударга байдал хангагдах эерэг нөлөөтэй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын хүрээнд эдийн засаг, бизнесийн орчин сайжирч, хөрөнгө оруулалт нэмэгдэж, татварын суурь өргөжнө.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хувилбар 6-гийн хүрээнд ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, хөдөлмөр эрхэлж буй иргэд, хувиараа бизнес эрхэлж буй иргэдийн орлого нэмэгдэж, нийгмийн байдал сайжрах дам нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр, байгаль орчинд ээлтэй техник, технологийг дэмжин ажилласнаар агаар, орчны бохирдлыг бууруулах эерэг нөлөө үзүүлнэ.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн олон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсан. Мөн Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван долдугаар зүйлийн 17.1.3-т зааснаар хуулиар ногдуулсан албан татварыг төлөх нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг бөгөөд энэхүү татварыг ногдуулах эрх хэмжээ нь УИХ хэрэгжүүлдэг байхаар хуульчилсан байна. Энэ агуулгаар аваад үзэхэд татварын хууль тогтоомж нь УИХ-аас батлагддаг байх ёстой бөгөөд татвар төлөх үүрэг нь зайлшгүй байж, энэ нь нийгмийн харилцааг зохицуулах төсвийн суурь болдог.

Түүнчлэн Монгол Улс 2017 оны 12 дугаар сард Татварын суурь бууруулах ашиг шилжүүлэхийн эсрэг олон улсын байгууллагад нэгдэн орсноор татварын зорилгоор мэдээлэл солилцох үүрэг амлалтыг аваад байгаа. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Иймд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;

- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын төрийн бодлоготой уялдуулан эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлт, ажил олголт, хөрөнгө оруулалтыг дэмжсэн тэгш шударга, өрсөлдөхүйц, олон улсын жишигт нийцсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэхийн тулд зөвхөн хувилбар 6 буюу хууль батлан хэрэгжүүлснээр өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаврыг бууруулах, зорилтыг хангах боломжтой байна. Энэхүү зохицуулалтыг хуульд тусгахдаа оновчтой хэлбэрээр хуульчлахгүй бол эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг нэмэгдүүлэх эрсдэл учирч болох юм.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа Татварын ерөнхий хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төсөлтэй нягт уялдуулсан. Хуулийн төслийг боловсруулахдаа дараах олон улсын болон бусад улс орны эрх зүйн зохицуулалтыг судлан үзсэн болно.

- Татварын ил тод байдлыг хангах, татвараас зайлсхийхийн эсрэг авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 350 дугаар тогтоолын дагуу элсэн орж, үүрэг амлалт хүлээсэн “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллага”, “Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны олон улсын форум” зэрэг байгууллагын стандарт, тавигддаг шаардлага, татвараас зайлсхийхийн эсрэг олон улсын шинэ дүрмүүд;
- Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага, Нэгдсэн үндэсний байгууллагын боловсруулсан давхар татварын гэрээний загварууд, тэдний дэлгэрэнгүй тайлбарууд;

- Кэй Пи Эм Жи компанийн нийтэлсэн дэлхийн улс орнуудын Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээний талаарх мэдээлэл;
- ПрайсУотерхаусКүпэрс компанийн нийтэлсэн дэлхийн улс орнуудын хувь хүний орлогын албан татварын ногдуулалт, төлөлтийн талаар мэдээлэл;
- Дэлхийн банкны нийтэлсэн бизнесийн орчны судалгаа, түүний дотроос татвар ногдуулалт, төлөлтийн талаар бусад улсын талаар мэдээлэл;
- Хөгжлийн хамтрагч байгууллагуудаас татварын хууль тогтоомжид өгч байсан зөвлөмжүүд, техникийн тайлангууд зэрэг болно.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Хөрөнгө оруулалт, бизнесийг дэмжсэн, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ажлын байр шинээр бий болгох, тэгш шударга, үр ашигтай татварын тогтолцоог бий болгох, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуультай уялдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах асуудлыг урьдчилан тандан судлах ажиллагааг гүйцэтгэлээ.

Харьцуулалтын үр дүнг харгалзан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь зорилгод хүрэх боломжтой цорын ганц оновчтой хувилбар гэж дүгнэж байна.

-----o0o-----

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Татварын харилцаанд тэгш шударга байх зарчмыг баримтлан хуульчилна.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Хувь хүний орлогын албан татвар ногдуулах төлөх, сонголтыг олгох бөгөөд нийгмийн аль нэг хэсэгт давуу байдал олгосон зохицуулалт байхгүй
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох төрийн болон ТББ, татвар төлөгч зэрэг эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Татварын ил тод, шударга байдал сайжирч, иргэдийн татварын ачаалал буурснаар татвар төлөгчдийн эрхийг хангах, тэгш шударга байх зарчимд дэвшил гарна.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Бүрэн нийцнэ.
1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Татварын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар зохицуулах тул энэ хуульд тусгагдахгүй.	
2. Хүний	2.1. Зохицуулалт нь хүний	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарлахгүй.

эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх			
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хязгаарлалт тогтоохгүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	<ul style="list-style-type: none"> • Татвар төлөгчид • Төрийн байгууллагууд • Татварын зорилгоор мэдээлэл хүргүүлэх бусад этгээд
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Албан татвар ногдох орлого, татвар ногдуулах орлогын хэмжээгээр ялгаатай ногдуулалт, төлөлт, хөнгөлөлт, тайлагналын горим үйлчилнэ.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Тодорхой тооноос доош борлуулалтын орлого бүхий татвар төлөгчийн татварын зардал, ачааллыг бууруулах, зорилгоор ялгаатай горим хэрэглэх боломж олгоно.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага орлоготой иргэд, анх удаагаа орон сууц худалдан авч буй иргэдэд татварын дэмжлэг үзүүлнэ.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	<ul style="list-style-type: none"> • Татвар төлөгч, • Татварын алба
4. Хүйсийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Хүйсийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хүйсийн эрх тэгш байдлыг хангах нөхцөлийг төсөлд анхаарч үзсэн
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шалгуур, сонгон шалгаруулалт, гэрээлэх үйл явц, хөдөлмөр эрхлэх, хяналтын бүх нөхцөлд хүйсийн тэгш байдлыг бүрдүүлсэн.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй. олон улсын татварын нийтлэг зарчмын дагуу татвар ногдуулна.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	байршил өөрчлөгдөхийг оролцуулан)			
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирүүлэхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Татварын хялбаршуулсан горим гэх зэрэг олон бодлогын арга хэмжээгээр дэмжлэг үзүүлнэ.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Татварын зардлыг бууруулах үр нөлөөтэй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгийн биржээр дамжуулан санхүүжилтийн эх үүсвэр олж авахад гарах зардлыг бууруулна.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжинэ
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Татварын ачаалал буурснаар өрхийн төсөвт эерэг нөлөө үзүүлнэ
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Татварын тэгш, шударга байдлыг хангах зорилгоор бүсчилж татвар ногдуулахгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Татварын хялбаршуулсан горим нэвтрүүлж татварын зардлыг бууруулна.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төсөвт эерэг нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нийтлэгээр бус гэрээ байгуулсан тохиолдолд хуулийн дагуу чиг үүрэг үүснэ.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Хөрөнгө оруулалтыг нэмэх, ажлын байр бий болгоход эерэг

	хөгжлийг дэмжих эсэх			нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Хувиараа хөдөлмөр эрхлэх болон шинээр ажлын байр бий болгох үйл ажиллагаа дэмжинэ
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр буурах үр нөлөө гарахгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Өөрчлөлт бий болгохгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Үүсгэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал,	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Орон сууцжуулах үйл ажиллагааг дэмжин ажилласнаар агаар, орчны бохирдол буурах зэрэг нөлөөг үзүүлнэ.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.

	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлын эсрэг татварын дэмжлэг үзүүлнэ.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.

5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Орчны бохирдол, хаягдлын эсрэг татварын хөнгөлөлт үзүүлнэ.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөхгүй.

-----oOo-----

ХУВЬ ХҮНИЙ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ. Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн төслийн шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулагдсан.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”²-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттай хийлээ:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Энэ үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д³ заасныг үндэслэн зургаан шалгуур үзүүлэлтээс дараах дөрвөн шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаатай байдал зэрэг болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Хуулийн төслийн зохицуулалт нь анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэх, хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн

¹ www.legalinfo.mn.

²Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

³ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тооцох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож авсан.

2.Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төсөлд Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч хувь хүнийг тодорхойлох шинэ шалгуурууд, албан татвар төлөгч хувь хүнд хялбаршуулсан журмаар албан татвар ногдуулах, албан татвар төлөгчийн гадаад улсад төлсөн албан татварыг хөнгөлөх тухай зохицуулалтыг тусгасан. Эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодруулах шаардлагатай байгааг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

3.Ойлгомжтой байдал:

Хуулийг дагаж мөрдөх, хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой байгаа эсэх, хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд уялдаатай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбар байгаа эсэхийг тогтоох зорилгоор энэ шалгуур үзүүлэлтийг сонгов.

4.Харилцан уялдаа:

Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо зөрчилгүй, уялдаатай байх, хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх, хуулиар үүрэг хүлээсэн этгээдийн чиг үүрэг давхардсан, эсхүл зөрчилдөж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор энэ шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтад хамаарах этгээд хуулийн төслийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “**хүлээн зөвшөөрөгдөх байдал**” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно. Мөн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөц хэмнэх зорилгоор “**зардал тооцох**” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 15.6 дахь хэсэг, 23, 24 дүгээр зүйл	Хуулийн төсөл дээр татвар төлөгчид, татварын хуулийг хэрэглэх этгээдүүдтэй нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийн төсөлд ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төсөлд иргэд, хуулийн этгээдийн ирүүлсэн саналд дүгнэлт хийх, Хууль тогтоомжийг тухай хуульд заасан аргачлалд нийцсэн эсэхийг нягтлах.

4	Харилцан уялдаа зэрэг болно.	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 дахь заалт болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан байдлыг шалгах.
---	------------------------------	---	---

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙДАЛ

1.Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах үндсэн зорилтуудыг дэвшүүлсэн байна:

1. хуулийг энгийн, ойлгомжтой болгох, хийдлийг бууруулах;
2. татвар төлөгчийн татварын ачааллыг нэмэгдүүлэхгүй байж, бизнесийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
3. хялбаршуулсан татварын горим нэвтрүүлж, татвар төлөгч, татварын албаны хууль тогтоомж хэрэгжүүлэх зардлыг бууруулах;
4. Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулах.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Зорилт-1. хуулийг энгийн, ойлгомжтой болгох, хийдлийг бууруулах

Хуулийн төслийн **5 дугаар зүйлд** албан татвар төлөгчийн статусыг, **10, 11 дүгээр зүйлд** хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, шууд бус орлогын хамрах хүрээг илүү тодорхой болгож өгсөн. Түүнчлэн төслийн **25, 26, 27 дугаар зүйлд** албан татварыг суутгах тооцох, төлөх, тайлагнах асуудлыг дэлгэрэнгүй тусгаж өгсөн болно.

Зорилт-2. татвар төлөгчийн татварын ачааллыг нэмэгдүүлэхгүй байж, бизнесийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Хуулийн төслийн **21 дүгээр зүйлд** албан татварын хувь хэмжээг зааж өгсөн. Албан татвар төлөгч хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлсний орлого, шууд бус орлого, үйл ажиллагааны орлого болон хөрөнгийн орлогод ногдуулах татварын хувь өөрчлөгдөхгүй 10 хувь байна. Үүнтэй адилаар үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод 2 хувь, бусад биет болон биет бус хөрөнгө борлуулсны орлогод 10 хувиар албан татвар ногдуулна. Түүнчлэн, албан татвар төлөгч хувь хүний төсөвт төлөх татварын ачааллыг дараах зохицуулалтын хүрээнд бууруулна:

- хуулийн төслийн **23 дугаар зүйлийн** 23.3, 23.4-т заасны дагуу орон сууц худалдан авсан Монгол Улсын иргэн хувь хүнд үзүүлэх татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлнэ;

- хуулийн төслийн 24 дүгээр зүйлд Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн гадаад улсад төлсөн татварыг хасаж, давхар татварыг арилгах зохицуулалтыг тусгав.

Зорилт- 3. хялбаршуулсан татварын горим нэвтрүүлж, татвар төлөгч, татварын албаны хууль тогтоомж хэрэгжүүлэх зардлыг бууруулах

Хуулийн төслийн **15 дугаар зүйлийн** 15.6-д заасны дагуу жилийн борлуулалтын орлого нь 50.0 сая төгрөгөөс бага хувь хүн өөрөө хүсэлт гарган хялбаршуулсан журмаар татварын тайлан гаргаж, тооцоо хийх боломжтой. Түүнчлэн, хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1.3, **19 дүгээр зүйлд заасан** худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч хувь хүн тогтмол татвар төлөх боломжтой.

Зорилт- 4. Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулах

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн **4 дүгээр зүйлд** заасан нэр томъёог Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд туссан нэр томъёотой уялдуулан тодорхойлсон. Нөгөө талаас, хуулийн төслийн **15 дугаар зүйлд** үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан холбогдох зарчим, зохицуулалтыг баримтлахаар тусгав.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 15.6 дахь хэсэг, 23, 24 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг **“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг тодруулахыг зорьсон болно. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд татвар төлөгч, татварын албад, судлаач нарын дунд улс орны хэмжээнд хэлэлцүүлэг хийж санал, хүсэлтийг авсан. Эдгээр санал хүсэлтийг нэгтгэн хуулийн төсөлд тусгах боломжтой гэж үзсэн саналуудыг тусгасан байна.

3. Ойлгомжтой байдлыг хангасан эсэх:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ. Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалд санал авахаар Засгийн газрын бүх гишүүдэд хүргүүлсэн. Түүнчлэн, хуулийн төслийг Сангийн яам, Татварын ерөнхий газрын албан ёсны цахим хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авсан. Хуулийн төсөлд холбогдох мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагын саналыг авч ажилласан.

4. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д дурдагдсан нийтлэг шаардлагуудаас харилцан уялдаатай холбогдох 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т заасан нийтлэг шаардлагууд болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:*

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон УИХ, Засгийн газрын баталсан холбогдох баримт бичиг, үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөхгүй.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заажгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Энэхүү хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн заалтуудыг иш татсан байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулж өнөөгийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.

3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгагдсан нэр томьёо тус хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой уялдана. Хуулийн төсөлд тусгагдсан нэр томьёо нь Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдсан.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Зарчмын зөрөөтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч этгээдүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм	Төрийн байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага"-аар гүйцэтгүүлэхээр зохицуулах боломжтой.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй Зохицуулалт тусгаагүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой
15	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.

	тусгагдсан эсэх;		
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.		Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдсан болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгын дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн⁴ 17 дугаар зүйлд заасны дагуу хийв. Шинэчлэн найруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төсөл нь хуулийг энгийн, ойлгомжтой болгох, бичил худалдаа ажил үйлчилгээ эрхлэгч болон жижиг дунд татвар төлөгчдийн тайлагналыг хөнгөвчлөх, ачааллыг бууруулах, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг дэмжих чиглэлд тодорхой зохицуулалтыг тусган боловсруулжээ.

Зөвлөмж:

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлангаас дараах зөвлөмжийг гаргасан:

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэд, олон нийт, мэргэжлийн холбоод аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн саналыг судлан үзэж, хуулийн төсөлд тусгах;
2. хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс иргэдийн татварын боловсролыг дээшлүүлэх;
3. татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахын тулд татварын тайлан, тооцоо хийдэг байх;
4. хуулийг дагалдан гарах холбогдох дүрэм, журмын төслийг олон нийтээр хэлэлцүүлэн, холбогдох саналыг авч ажиллах.

---o0o---

⁴Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зардлын тооцоог хийлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах болно. Энэхүү тооцоололд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд болон татварын албаны зардлыг тооцсон болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн этгээдийн зардлыг Аргачлалд зааснаар дараах байдлаар тооцов.
Үүнд:

1.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулийн төсөлд заасны дагуу хуулийн этгээд нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- хувь хүнд олгосон орлогоос албан татвар суутгаж, суутган тооцоололтой холбоотой тайлан, мэдээ, тодруулга гаргаж татварын албанд тушаах;
- хувь хүний орлогын албан татварыг төсөвт шилжүүлэх.

1.2.Зардлыг тооцох

Зардлыг тооцохдоо хуулийн этгээдийн 2017 онд татварын албанд хүргүүлсэн суутган тайлангийн үзүүлэлтэд үндэслэж хийсэн. Нягтлан бодогч санхүү, татвар, нийгмийн даатгалын болон бусад тайлан гаргах сарын дундаж зардлыг 616 000 төгрөг байна гэж төсөөлөв. Ажиллах хугацааг энэ аргачлалын “хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загвар”-т заасны дагуу дор үзүүлсэн хүснэгтээр тооцон үзэхэд дараах байдалтай байна:

№	Ерөнхий үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)		
		Энгийн	Дунд	Бүрэн
1	Үүрэгтэй танилцах, судлах	10.0	12.0	15.0
2	Мэдээлэл цуглуулах	10.0	12.0	15.0
3	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	60.0	72.0	90.0
4	Тооцоо хийх	60.0	72.0	90.0
5	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	30.0	36.0	45.0
6	Алдааг засах	30.0	36.0	45.0
7	Тоо баримтыг боловсруулах	10.0	12.0	15.0
8	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	10.0	12.0	15.0
9	Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	-	-	-
10	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	-	-	-
11	Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	10.0	12.0	15.0
12	Олшруулах, архивлах, тараах	5.0	6.0	7.5

13	Төрийн захиргааны байгууллагаас шалгах	5.0	6.0	7.5
14	Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	-	-	-
15	Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	-	-	-
16	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	-	-	-
	Нийт	240.0	288.0	360.0

Сард 168 ажлын цаг, улиралд 504 ажлын цаг байна гэж үзэж (тайланг улиралд нэг удаа татварын албанд хүргүүлнэ), холбогдох тооцоог хийв.

Ажлын хөлс нэг цагт = $616,000/168 = 3,666.67$ төгрөг

Зардал (тус бүрийн)=Хугацаа × Ажлын хөлс = $3,666.67 \times 4$ цаг = 14,666.67 төгрөг болно.

1.3.Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт = тохиолдлын тоо * давтамжийн тоо

Тохиолдлын тоо = 116,190 (ирүүлсэн суутган тайлан) * 4 (улирал бүр) = 464,760

1.4.Нийт зардлыг тооцох

Нийт зардал = зардал * тоон үзүүлэлт = $14,666.67$ төгрөг * 464,760 = 6.8 тэрбум төгрөг (жилд)

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд хуулийн этгээд нь хувь хүнд олгосон орлогод холбогдох татварыг суутган, төсөвт шилжүүлэх үүргийг хүлээж, тайлан гаргадаг. Иймээс хууль батлагдсанаар хуулийн этгээдийн хууль дагаж мөрдөхөд зарцуулдаг зардал өнөөгийн хэмжээнээс нэмэгдэхгүй.

1.5.Хялбарчлах боломж

Хувь хүний орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор хуулийн этгээдийн зардлыг бууруулах боломжийг Аргачлалд заасны дагуу дараах шалгууруудаар тодорхойлж үзлээ. Үүнд:

- **Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:** Татварын ерөнхий хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлэх шаардлагатай хуулийн этгээдүүдийг бүрэн бүртгэж, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан үүргүүдийг хүлээлгэнэ. Иймээс хамрагдах хуулийн этгээдийн тоог бууруулах боломжгүй. Гэхдээ хуулийн этгээд нь хувь хүнд олгож буй орлогоос холбогдох татварыг суутгаж, тайлагнах тохиолдолд тухайн хувь хүн уг орлогод ногдуулан төлөх татварын тайлан, тооцоог татварын албатай хийх шаардлагагүй. Энэ тохиолдолд суутган төлөгч хуулийн этгээдэд тодорхой хэмжээний ачаалал ирж байгаа боловч татвар төлөгч хувь хүн, татварын тайлан тооцоог хүлээн авах, хянах, шалгах татварын албаны зардал буурна;
- **Мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасны дагуу хувь хүнд орлого олгож буй суутган төлөгч тухайн хувь хүнд олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн

дэвтэрт тэмдэглэж, татварын албанд хүргүүлэх бөгөөд уг мэдээллийн агуулга давтамжийг бууруулах боломжгүй. Харин татварын албанд хүргүүлэх татварын тайлан, түүнийг бэлтгэх зааврыг татвар төлөгчид чирэгдэл багатай байхаар бэлтгэж болно;

- **Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:** хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэх тухай Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаагүй;
- **Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар зохицуулсан суутган тайланг цахимаар болон цаасан хэлбэрээр тайлагнах боломжтой бөгөөд 2017 оны байдлаар нийт суутган тайлан тушаасан хуулийн этгээдийн дийлэнх хувь нь цахимаар тайлан тушаасан байна;
- **Мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:** хуулийн этгээд хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгаж, төсөвт шилжүүлсэн тухай суутган тайланг зөвхөн харьяа татварын албанд хүргүүлнэ;
- **Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх:** Татварын алба татвар төлөгч хуулийн этгээдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг. Гэхдээ дээр дурдсанчлан дийлэнх татвар төлөгчид суутган тайланг цахимаар хүргүүлж хэвшсэн болно.

1.6.Нэмэлт зардлыг тооцох

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хуулийн этгээд нь хувь хүнд олгосон орлогод холбогдох татварыг суутган, төсөвт шилжүүлэх үүргийг хүлээж, тайлагнаж ирсэн. Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулж хуулийн этгээдийн татварын хууль тогтоомж дагаж, мөрдөхтэй холбоотой нэмэлт зардал гарахгүй.

Харин оршин суугч болон оршин суугч бус татвар төлөгч хувь хүний зарим төрлийн орлогод ногдуулах татварын хувь хэмжээг адил болгосноор хуулийн этгээдийн суутган тайлан гаргах, тооцоо хийх, залруулга хийх, төсөвт шилжүүлэх үйл ажиллагаа хялбар болж, зарцуулах цаг, зардал буурна.

ХОЁР. ИРГЭНИЙ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэний зардлын тооцоонд тухайн иргэний төсөвт төлөх албан татварыг оруулаагүй болно. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэний зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хувь хүн дараах үүргийг гүйцэтгэнэ:

- санхүүгийн анхан шатны баримтуудыг бүрдүүлж, Хувь хүний орлогын албан татварын тайлан гаргаж, төсөвт төлөх үүргийг гүйцэтгэнэ.

2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох

Зардлыг тооцохдоо иргэдийн татварын албанд хүргүүлсэн тайлангийн үзүүлэлтэд үндэслэж хийсэн бөгөөд дараах хугацааг зарцуулна гэж төсөөлөв.

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)		
		Энгийн	Дунд	Бүрэн
1	Үүрэгтэй танилцах	10.0	12.0	15.0
2	Мэргэжлийн зөвлөгөө авах (холбогдох газраас)	-	-	-
3	Мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллийг нэгтгэх	60.0	72.0	90.0
4	Цуглуулсан мэдээллээ боловсруулах (нягтлах, тооцоолох, шалгах гэх мэт)	60.0	72.0	90.0
5	Маягт бөглөх	120.0	144.0	180.0
6	Албан бичиг боловсруулах (захиа, факс, цахим шуудан гэх мэт)	-	-	-
7	Мэдээллээ холбогдох газарт илгээх	1.0	1.2	1.5
8	Төлбөр хийх	1.0	1.2	1.5
9	Баримт бичиг хуулбарлах үдэх, хадгалах	8.0	9.6	12.0
10	Төрийн эрх бүхий байгууллагаар шалгалт хийлгэх	-	-	-
11	Эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөх	40.0	48.0	60.0
	Нийт	300.0	360.0	450.0

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасны дагуу үйл ажиллагааны орлого болон бусад орлого олж буй иргэд жилд нэг удаа татварын тайлан гаргаж, харьяа татварын албанд хүргүүлэх үүрэгтэй

2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо × Давтамжийн тоо

118,416 = 118,416 (тайлангийн тоо) × 1 (давтамж)

2.4.Нийт дүнг тооцож гаргах;

Ачаалал=Цаг хугацаа × Тоон үзүүлэлт

592,080 цаг = 5 цаг × 118,416 тайлан

Нийт зардал= ачаалал × зардал = 592,080 * 3,666.67 (цагийн хөлсний өмнөх жишгийг баримтлав) = 2.2 тэрбум төгрөг

2.5.Хялбарчлах боломжийг шалгах

Хувь хүний гаргах зардлыг бууруулах боломжийг Аргачлалд заасны дагуу дараах шалгуураар тодорхойлов. Үүнд:

- **Хамрагдах иргэний тоог багасгах боломж байгаа эсэх:** татварын суурийг нэмэгдүүлэх, иргэдийн татвар төлөх идэвхийг нэмэгдүүлэх, татварын тэгш, шударга зарчмыг хангах нь хуулийн төслийн үндсэн зарчмын нэг тул татварт хамрагдах иргэдийн тоог бууруулах боломжгүй;
- **Мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:** үйл ажиллагаа эрхэлж буй, албан татвар ногдох орлого олсон хувь хүн жилд нэг удаа тайлан гаргах тул давтамжийн тоог багасгах боломжгүй. Харин жилийн 50.0 сая төгрөг буюу түүнээс бага борлуулалтын орлого олж буй хувь хүн

хялбаршуулсан горимоор тайлан гаргах боломжтой тул иргэдийн хууль тогтоомж дагаж мөрдөх зардал буурна;

- **Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төсөлд татвар төлөгч иргэнд шинээр үүрэг хүлээлгээгүй болно;
- **Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тайланг цахимаар болон цаасан хэлбэрээр тайлагнах боломжтой. Өнгөрсөн 2017 оны байдлаар татварын албанд ирүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тайлангийн дийлэнх хэсгийг цахимаар хүлээн авсан;

2.6.Нэмэлт зардлыг тооцох

Үйл ажиллагаа эрхэлж, албан татвар ногдох орлого олж буй албан татвар төлөгч хувь хүн өнөөгийн мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хуулийн дагуу жил бүр татварын тайлан гаргаж, харьяа татварын албанд хүргүүлдэг. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд албан татвар төлөгчийн татварын хууль тогтоомж дагаж мөрдөх зардлыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгаагүй.

Харин албан татвар төлөгчид хялбаршуулсан журмаар татварын тайлан тооцоо хийх боломжийг олгосноор түүний хууль дагаж мөрдөх зардал, татварын албаны татварын тайлан тооцоо хянах зардал буурна.

ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Монгол Улсын Татварын алба Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллана.

3.1.Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох:

Монгол Улсын татварын алба хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Хувь хүний орлогын албан татварын тайлан, мэдээ, тодруулгыг татвар төлөгчөөс хүлээн авч хянаж, баталгаажуулах, татвар төлөгчид үйлчлэх, хувь хүний орлогын албан татварыг хураах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Өнөөгийн байдлаар 601 орчим татварын улсын байцаагч Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү мэдээлэлд үндэслэн хуулийг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсон болно.

Хуулийн төсөлд Хувь хүний орлогын албан татварын тайлагналын тоо жилд нэг байхаар тусгасан бөгөөд иргэдийн орлогын хэмжээнээс нь хамааруулан тайлагналыг хялбарчилж байгаа болно. Хуулийн төсөлд тусгасан татварын албаны үйл ажиллагааг хөнгөвчилсэн болон шинээр олгосон эрхтэй холбоотойгоор хуулийг хэрэгжүүлэх явцад албан хаагчдын ажил үүргийн хуваарьт дотоод зохицуулалт хийж, хүний нөөцийг нэмэхгүйгээр одоогийн хэмжээнд ажиллах боломжтой.

3.3.Гарах зардлыг урьдчилан тооцох;

Татварын алба хуулийг хэрэгжүүлэхдээ хүний нөөцийн дотоод зохион байгуулалт хийж, бусад материаллаг зардлыг нэмэхгүй одоогийн хэмжээнд барьж ажиллах боломжтой.

Татварын улсын байцаагчийг төрийн албан хаагчийн ТЗ-6 зэрэглэлийн 2 дугаар шатлалаар цалинжуулж, бусад нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийг төр хариуцна гэж үзвэл нэг татварын улсын байцаагчийн цалин, хөдөлмөрийн хөлсний зардалд жилд дунджаар 9.9 сая төгрөг зарцуулахаар байна. Татварын алба 2017 онд 1905 орчим албан хаагчтай ажилласан бөгөөд ажлын байр, хөрөнгө оруулалттай холбоотойгоор 4.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ зардлыг байцаагчийн тоонд шилжүүлж үзвэл нэг байцагчид 2.3 орчим сая төгрөг зарцуулсан байна.

3.4.Зардлыг нэгтгэн тооцох

Нийт зардал = (хүний нөөцийн зардал + бусад зардал) × хүний нөөцийн хэрэгцээ = (9.9 сая төгрөг+2.3 сая төгрөг)*601 = 7.3 тэрбум төгрөг.

3.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувь хүний орлого, үйл ажиллагааны онцлог шинж чанартай уялдуулан хялбаршуулсан горимоор тайлагнах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Үүнээс үүдэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх зардал одоогийн хэмжээнээс буурна.

--oo00oo--

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЪЁОГ, ҮР ДҮН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.5, 38 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Сангийн яам, Татварын ерөнхий газар хамтран татварын шинэчлэлийн хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүртэл нийт 32 хоногийн хугацаанд улс орон даяар өргөн хүрээтэй зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн саналыг хүлээн авлаа. Энэ хугацаанд татвар төлөгч, иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, судлаач, эрдэмтэд, татварын байцаагчдын дунд Улаанбаатар хот болон бүх аймаг, дүүрэгт нийт 39 удаагийн танхимын хэлэлцүүлгийг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 4,790 хүн оролцож санал бодлоо илэрхийлсэн байна.

Түүнчлэн, Сангийн сайд, Сангийн яам, Татварын албаны цахим хаяг, фейсбүүк хуудас, твиттерээр дамжуулан хуулийн төслүүдтэй холбоотой санал сэтгэгдлүүдийг цахимаар хүлээн авч нэгтгэн боловсрууллаа.

Энэхүү олон нийтийн хэлэлцүүлгийн хүрээнд нийт 5,549 санал ирсэн бөгөөд үүнээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2,142 санал, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1,349 санал, Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1,182 санал, дагалдах бусад хуулийн төсөлд нийт 876 саналыг тус тус ирүүлсэн байна.

Нийт ирүүлсэн саналыг нэг бүрчлэн судалж үзээд 1,783 саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан бол 1,891 саналыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Мөн үлдсэн 1,875 санал нь сэтгэгдэл, асуулт хэлбэртэй байлаа. Ирсэн саналын дийлэнх нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын тайлагнал, хувь хэмжээ, хялбаршуулсан горим болон татварын ерөнхий орчинтой холбоотой байв.

Утга	Нийт	Хуулийн төслөөр					Санал тусгагдсан байдал			Саналын хандлага	
		ААНОАТ	ХХОАТ	ТЕХ	НӨАТ	Дагах	Авсан	Аваагүй	Сэтгэгдэл	Дэмжсэн	Дэмжээгүй
Хөнгөлөлт, чөлөөлөлт	901	135	665	12	83	6	301	383	217	139	26
Ерөнхий	854	145	158	399	44	108	349	182	323	279	24
Тайлагнал	519	136	89	127	162	5	111	144	264	38	19
Хялбаршуулалт	478	390	47	38	3	0	6	84	388	382	5
Хувь хэмжээ	475	177	190	3	92	13	104	230	141	54	44
Х тайлан	294	293	0	1	0	0	66	218	10	56	114
Хариуцлага	221	0	1	190	0	30	66	84	71	11	13
Босго	219	69	0	0	150	0	28	43	148	0	1
Хасагдах зардал	217	198	19	0	0	0	146	59	12	4	0
Өр барагдуулалт	171	0	0	169	0	2	49	47	75	38	4
Элэгдэл	164	164	0	0	0	0	77	77	10	21	3
Орлого	110	14	93	0	2	1	44	57	9	1	0
Бусад	926	421	87	243	171	4	436	283	207	40	7
НИЙТ	5,549	2,142	1,349	1,182	707	169	1,783	1,891	1,875	1,063	260

Бизнес эрхлэгчид Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан 3 тэрбум төгрөгийн босгыг 5, 6, 10, 15 болон 20 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэх санал гаргасныг нарийвчлан судлан үзэж,

ирүүлсэн саналын дагуу босгыг 6 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж төсөлд тусгасан. Түүнчлэн, хөрөнгийн биржээр нээлттэй арилжаалах бондын хүүгийн орлогод 5 хувиар ногдуулж байгааг банк, дотоод, гадаад гэж ялгалгүй нэгэн ижил мөрдөх санал гаргасныг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан. Түүнчлэн, Ахмад настныг дэмжих тухай хуулиар заасан санд төвлөрүүлсэн хөрөнгийг хасагдах зардлаар хүлээн зөвшөөрдөг болох, хөгжлийн бэрхшээлтэй иргэний орлогын албан татвараас чөлөөлөх зэрэг нийгмийн шинж чанартай саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан болно.

Эцсийн эзэмшигчийн тодорхойлолт, татвар ногдуулах, төлөх, тайлагнах харилцаа ойлгомжгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа талаар хэлэлцүүлгийн явцад нэлээдгүй санал гаргасан тул энэ асуудлаар тусгайлсан хэлэлцүүлэг хийж, холбогдох зохицуулалтыг энгийн, ойлгомжтой хэрэгжүүлэхэд хялбар болгосон.

Үнэ шилжилтийн асуудал нь зөвхөн татвар төлөгч аж ахуйн нэгжийн асуудал биш тул энэ зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар бус Татварын ерөнхий хуулийн дагуу зохицуулах нь зүйтэй гэсэн саналыг хэлэлцүүлгийн явцад гаргаж байсныг хүлээн авсан. Энэ асуудалтай холбоотойгоор үнэ шилжилтийн тохируулга хийх зарчмыг олон улсын туршлага, жишиг, стандартад нийцүүлэн хуулийн төсөлд тусгасан.

Татвар төлөгчийн эрхийг хамгаалах зорилгоор татварын хариуцлагатай холбоотой зохицуулалтыг Зөрчлийн тухай хуулиар биш Татварын ерөнхий хуулиар хариуцлага ногдуулж, прокурорын хяналтгүй захиргааны журмаар асуудлыг шийдвэрлэхээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулсан болно.

Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргахдаа нөхөн ногдуулсан татварын 10 хувийг төлөхөөр байгааг бууруулах, эсхүл тодорхой хязгаар тогтоож оруулах саналыг хэлэлцүүлгийн явцад иргэд, хуулийн этгээдээс гаргасан тул энэ саналыг хүлээн авч тус зөвлөлд гомдол гаргах барьцааны хэмжээг 100 сая төгрөгөөр хязгаарлаж өгсөн болно.

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг дэмжих, зээлийн хүүг бууруулах зорилгоор санхүүгийн хэрэгслийг НӨАТ-аас чөлөөлөх саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан болно.

Харин, хялбаршуулсан татвар ногдуулах босгыг нэмэгдүүлэх, НӨАТ ногдуулах босгыг бууруулж бүх иргэд аж ахуйн нэгжийг НӨАТ-д хамруулах саналыг хүлээн аваагүй болно. Хувь хүний шууд бус орлогыг албан татвараас чөлөөлөх, мал бүхий этгээд, малчин өрхөөс малын хөлийн татвар саналыг дэмжээгүй.

Татварын тэгш, шударга зарчмыг баримтлах үүднээс иргэд, аж ахуйн нэгжээс хэлэлцүүлгийн явцад гаргасан зарим төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх саналыг хүлээн аваагүй болно.



Эхлэл / Мэдээ, Мэдээлэл / ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮНГҮҮД - I

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ


ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮНГҮҮД - I

Мэдээлэл нийтлэсэн: Сангийн яам

Нийтлэсэн огноо: 2018 оны 04 сарын 27

ЖИРГЭХ

ХУВААЛЦАХ



САНГИЙН ЯАМ

ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

2018 оны 04 дүгээр сарын 26



САНГИЙН ЯАМ

ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

2018-02-23-ААС 2018-03-27 ӨДРИЙГ ХҮРТЭЛ НИЙТ **32 ХОНОГИЙН** ХУГАЦААНД УЛС ОРОН ДАЯАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЖ НИЙТ **5,549** САНАЛ ХҮЛЭЭН АВЛАА

39 УДААГИЙН ТАНХИМЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ 4,790 ХҮН ОРОЛЦОЖ 3,638 САНАЛ ӨГЛӨӨ	ЦАХИМ СҮЛЖЭЭ БОЛОН БИЧГЭЭР НИЙТ 1,911 САНАЛ ХҮЛЭЭН АВЛАА
--	---

- Бизнес эрхлэгчдийн төлөөлөл:**
МУХАУТ, CEO клуб, Монголын бизнесийн зөвлөл болон компаниудын төлөөлөл
- Хөрөнгө оруулагч, олон улсын байгууллагын төлөөлөл:**
Гадаад улс орнуудын худалдааны танхимууд, олон улсын байгууллагууд.
- Иргэдийн төлөөлөл:**
Үйлдвэрчний эвлэл, олон нийтийн байгууллага, иргэд.
- Төрийн бус байгууллагын төлөөлөл:**

 www.mof.gov.mn

 facebook.com/Hurelbaatarc

 facebook.com/MOFMongolia


 [@KhurelbaatarCh](https://twitter.com/KhurelbaatarCh)




САНГИЙН ЯАМ

ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ИРСЭН САНАЛЫН ХАНДЛАГА

Ирсэн саналын ангилал



Саналын хандлага



САНГИЙН ЯАМ

ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕЭР ХАМГИЙН ИХ ХӨНДӨГДСӨН АСУУДЛУУД

№	Утга	Нийт	Хуулийн төслөөр					Санал тусгагдсан байдал			Саналын хандлага	
			ААНОАТ	ХХОАТ	ТЕХ	НӨАТ	Дагах	Авсан	Аваагүй	Сэтгэгдэл	Дэмжсэн	Дэмжээгүй
1	Хөнгөлөлт, чөлөөлөлт	901	135	665	12	83	6	301	383	217	139	26
2	Ерөний санал	854	145	158	399	44	108	349	182	323	279	24
3	Тайлан	519	136	89	127	162	5	111	144	264	38	19
4	Хялбаршуулалт	478	390	47	38	3	0	6	84	388	382	5
5	Хувь хэмжээ	475	177	190	3	92	13	104	230	141	54	44
6	Х тайлан	294	293	0	1	0	0	66	218	10	56	114
7	Хариуцлага	221	0	1	190	0	30	66	84	71	11	13
8	Босго, шатал	219	69	0	0	150	0	28	43	148	0	1
9	Хасагдах зардал	217	198	19	0	0	0	146	59	12	4	0
10	Эр барагдуулалт	171	0	0	169	0	2	49	47	75	38	4
11	Элэгдэл	164	164	0	0	0	0	77	77	10	21	3
12	Орлого	110	14	93	0	2	1	44	57	9	1	0
13	Бусад	926	421	87	243	171	4	436	283	207	40	7